

Самсара: Бүтээлүүдийн тайлбар

Уран бүтээлч: П.Содгэрэл

- 1

Energy / Эрчис, 2024
Mixed media, 60 x 100cm

Хорвоо ертөнц, түмэн бодис эмх замбараагүй мэт боловч эрчисийн айлчлэл дунд дотоод эмх нэн цэгцтэй, өнө мөнх эргэлдэнэ.
- 2

Samsara II / Самсара II, 2025
Mixed media, 50 x 70cm

Монголчуудын язгуур шүтлэг болох бөө мөргөлд эцгийн цагаан дусал, эхийн улаан дусал, сүнсний алтан дусал гурав нэгдэж гэмээн амь бүрэлдэн тогтдог гэж үздэг. Мэлмий хүрэхээс эс хүрэх олон хэмжээст орчлонд хүмүүн эхийн хэвлээс унасан цагаас, магадгүй эхийн хэвлийд буй болсон цагаас хорвоод эдлэх зовлон жаргал нь эхэлмэй.
- 3

Samsara I / Самсара I, 2025
Mixed media, 50 x 70cm

Эр эм заяан аль ч оноолтод хүмүүн гэгч өнө эртний түмэн дээд эсийн үргэлжлэл, огт оргүйн чинадаас улбаат эрчист алтан сүнс эцгийн цагаан дусал, эхийн улаан дусалны цогц нийлбэр тул мөн чанарын хувьд орь ганцаар бус олон тоон дээр оршдог.
- 4

The Ibx Perch / Тэхийн зогсоол, 2022
Mixed media, 50 x 70cm

Тээр жилийн тэр нэг өвлийн өнөтэйг яана, Тэхийн зогсоол гэдэг тэр оргилын өндрийг яана Хүрэн уулсын өвдөж мухар, Хүүш нэртэй, Хүрэхэд хол ч буйлжхад нөмөр хөөс биуцтай. Хүрэн уулсыг халуун намраар аав минь зорив Хүүшийн өвөлжөөнд гурван гэрээр айл өвөлжив.

Өвөлжөөг хүрээлсэн уулсын оргил бүгд өндөр Өндрийн дундаас Тэхийн зогсоол бүүр ч өндөр Өвөлжөөнд буугаад аав хэсэг зуур ан хийв Өвөлд бэлдээд айлууд, хэсэг зуур ажил хийв.

Өнөтэй жилийн тэр нэгэн өвлийн дулаахныг хэлэх үү Өвс цас тэгшхэн ууланд өвөлжихийн тухтайг хэлэх үү

Говийн ууланд жам ёсоороо хавар ирэв Гол бараадаж гурван гэрээрээ нүүх болов. Нэгэн өглөө аав минь намайг гаднаас дуудав Нэг нүдний сунадаг дурангаа гарт бариулав.

-Тэхийн зогсоол дээр юу байна, сайн хар! гэв, Тэгж хэлснийхээ жаахан хойно санаа алдав.

Үзүүр нь гурвалжин, үүлэнд шүргэх оргил харагдав Үүрээ манан өндөрт эргэх бүргэд харагдав. Дэргэдэх оргил нь илээд авахаар ойрхон байв Дээрх тэнгэр нь нүдэнд торохоор үүлгүй байв”

– Тэхийн зогсоол дээр хараагаа тогтоо! гэж аав минь хэлэв Тэрүүн дээр нэг амьтан бий, ол доо гэж ахин хэлэв. Өвөлжин харагдаж нүдэнд дассан оргил үзэгдэв Орой дээр нь эвэр нь сэрийсэн янгир харагдав.

Хангайн сайхан амьтныг үзээд би баясав -Харлаг тэх зогсож байна! гээд би бараг хаширав. Аав минь дуугүй, тамхиа сорсоор гэртээ оров Айлын хүмүүс янгирын сургаар манайд цуглав.

Цайгаа ч уухгүй аав минь тэгээд хэсэг суув Цаанаа л гунигтай хоолой засаад ингэж ярив: – Мөнгөн оройт уулсын хишгийг их хүртлээ Мөнхийн зогсоолдоо зогссон янгирыг анх үзлээ.

Ямаан усанд ноднин байсан тэх мөн байна Яах аргагүй зогсоолдоо зогссон тэх мөн байна. Төрсний эцэст үхнээ гэдэг амьтны ёс оо, Төрсөн нутгаа орхиноо гэдэг амаргүй даваа

Янгир өтлөхөөрөө эврээ даахаа больдог юм гэнэлээ Янгирын сүргээ гүйцэж чадахаа байдаг юм гэнэлээ. Эхээс төрсөн ууландаа эргэж ирдэг юм гэнэлээ Эхээс унасан газраа олж хэвтдэг юм гэнэлээ.

Насныхаа эцэст оргил өөд мацаж гардаг юм гэнэлээ Нартад түүнийг нь Тэхийн зогсоол гэж нэрлэдэг юм гэнэлээ.

Өндөр оргил дээр олон хоног зогсдог юм гэнэлээ Өнгөрүүлсэн амьдралаа эргэж нэг хардаг юм гэнэлээ. Умдалдаг ариухан усаа үзэж нэг баярладаг юм гэнэлээ Идээлдэг сайхан бэлчээрээ харж нэг баясдаг юм гэнэлээ.

Ижил олон сүргээ эцсийн удаа үздэг юм гэнэлээ Эх болсон нутгаа сүүлчийн удаа хардаг юм гэнэлээ. Өндөр оргилоос эвэр нь дийлээд халдаг юм гэнэлээ Өнгөт орчлонгоос нэг нь тэгээд дутдаг юм гэнэлээ.

Аавын яриаг хүн бүхэн дуугүй чагнав Айлын эмээ янгирыг өрөвдөн нулимс унагав. Тэрнээс хойш аав минь нэг л зовиуртай болов Тэр өвөлжөөнөөс хэсэгтээ нэг л нүүхээ байв.

Гурван гэрийн хонины ээлж дороо эргэнэ Гуравхан хоногт манай ээлж эргээд ирнэ. – Өндөр өөд хонио бүү бэлчээ, гэж аав минь захиана Өглөө болгон л гаднаа сууж оргил дурандана.

Хүүшийн өвөлжөөнд чандамлаж буусан гурван айл Хүмүүсийн харааг өөртөө татсан гурвалжин оргил Цэнхэр тэнгэрт эвэр нь сэрийсэн харлаг тэх Чанх дээр нь өдөржин эргэсэн хүрэн бүргэд!

Ийм л зураг олон хоногоор аавд минь харагдав Энэ л зураг олон хоногоор өвөлжөөнд суулгав.

Нэгэн өглөө оргилыг дурандаад аав орж ирэв Нэг харахнаа баяртай мишээгээд цайгаа ууж суув. – Яг л ёсоороо хальж дээ хөөрхий! гэж аав минь ярив – Яамай даа яамай, хөөрхий минь! гэж ижий өрөвдөв.

Маргааш өглөө нь гурван гэр маань эрт ачаалав Манарсан бууцнаас хүн, мал маань зэрэг хөдлөв. Тэхийн зогсоол оргилыг аав минь нэг эргэж харав – Төрсөн нутаг минь! гэж эцэг минь нэг өөртөө хэлэв.

Тээр жилийн тэр нэгэн өвлийн уртыг яана! Тэхийн зогсоол гэдэг тэр оргилын өндрийг яана!

Б.Явуухулан 1969 он
- 5

A Ray of Light – I / Гийхүй – 1, 2021
Mixed media, 50 x 70cm

Байгалийн унаган тогтогч мэт бэхэн будгийн урсац, уян чанар, ус бэхний мөргөлдөөний үр тод бүдэг, тэгш муруй зургаасууд яг л сүнслэг оршихуй, биет ба биет бусын заагийг баллан бүдгэрүүлэх мэт агаад тэр бүхний дундаас тодрон цийх орон зай нь хүрээлэн буй орчин тодрон бэхжиж нэгэн амь гэрэл юугаан сацруулан энэхэн замбуулинд бүрэлдэн тогтох лугаа адил.

Ухамсрын чанад дахь түмэн нугачаа мэт хар, саарал, цагаанаар сүлэлдэн байх нимгэн бичилт нь хүмүүний нэгэн насны тааварлашгүй амьдралын зовлон жаргалын илэрхийлэл агаад төсөөллийн орон зайг огт оргүйн зүг тэлэн түүчээлнэ.
- 6

Nature’s Essence / Байгалийн амин сүнс, 2022
Mixed media, 50 x 70cm

Бидний өвөг дээдэс өнө эртнээс алив бүхнийг амьтай хэмээн үзэж, байх гал (байгаль)-аа өөрийн бодгиас илүү хайрлан дээдэлж ирсэн гүн ухаантууд билээ. Эдийг эдлэвч эрдмийг илүү дээдэлдэг өвгөдийн үр хойч болохын хувьд байгалийнхаа тэнвэрийг хадгалж, жаргал зовлон сүлэлдэн орших өнгөт орчлонд энх тунх, эрүүл жаргалтай, зовхи дээшээ, тэмүүлэл тэнгэрлэг, бэлгэ дүүрэн ерөөлийг билгийн мэлмийд тань өргөн барьюу.
- 7

Deer Totem – 2 / Буган Сүлд – 2, 2024
Mixed media, 60 x 100cm

Нараа даган нүүдэллэх талын нүүдэлчид алив бүхнийг амьтайд үзэж, байгальтайгаа шүтэлцэн дуу хууртай, домог туульстай, дуурсах түүхтэй, эрэмгий дайчид явсан билээ.
- 8

Deer Totem – 1 / Буган Сүлд – 1, 2023
Mixed media, 60x100

Талын нүүдэлчдийн эртний шүтээн нар, саран дор буган сүлдэт эрэлхэг баатар хүмүүний эрчист сүнсэн бие, буган уналгаа хөлөглөн эрхэст тэнгэртээ орчихуй, этүгэн эхийн хэвэлд буган чулуу босмуй.
- 9

A Deer Heard / Бугын анир, 2023
Mixed media, 60 x 100cm

Буга хэмээгч амьтны гоо сайхан, сонор сэргэг чанарыг акрил, хятад зургийн бэхний хоршлоор тодотгон харуулахыг урьсн бүртээл юм. Бүрэн үрхний сайтай, үр өгөөж арвин учир эртнээс хүн төрөлхтний хүнс тэжээлийн гол эх үүсвэр, хувцас эдлэлээ урлах материал нь байж. Энэхүү ивгээлт чанараараа эртний хүмүүсийн сахус шүтээн болсныг өнөө бид Монгол Улс болон бүс нутгуудад тархан буй буган хөшөө хиргэсүүрийн соёл археологийн үнэт өвөөс үзэж бишрэн суугаа билээ. Усгал зөөлөн харцарааа эртний нууцыг өгүүлэн, ухаж сайн судлаач, ахиухан нэг өнгийгөөч, анирдаж та минь сонсооч гээд байх мэт төсөөллийн орон зайг хязгааргүйд тэлнэ. Үхширмэл мэт улиангараас урган цэцэглэх алаг цэцэгс эрээнтэй бараантай орчлонгийн мөнхийн эргэлтийн бэлэгдэл билээ.
- 10

A Ray of Light – 2 / Гийхүй – 2, 2022
Mixed media, 50 x 60cm

Бүтээлийн дээд төвд түмэн бодис, сав шим ертөнц, дэлхий ээж, мөнх тэнгэр, байх гал, амьтан, ургамал, хүн төрөлхтөн цөм оргүйгээс үүдэлтэйг өгүүлнэ. Хүмүүн төрөлт бидний мэргэн ухаан, төсөөлөл ер булсын орчинд хүрсэн ч орчлон ертөнцийн туйлын нууцыг бүрэн тайлж чадаагүй хэвээр. Түмэн өнгийн дагнааст сав шим ертөнцийн мөнх эргэлт, нэгэн насны ахархан мөчлөгт өөр өөрийн сонгосон талбартаа хийж бүтээн гийж явах учиртай, хүмүүн заяанд төрсөн билээ, бид.
- 11

Orchikui – 2 / Орчихуй – 2, 2024
Mixed media, 100 x 100 cm (triangle)

Монголчуудын язгуур шүтлэг болох бөө мөргөлд эцгийн цагаан дусал, эхийн улаан дусал, сүнсний алтан дусал гурав нэгдэж гэмээ нь амь бүрэлдэн тогтдог гэж үздэг. Эр бэлгийн эс өндгөн эстэй нийлэх эгшинд супернова мэт гэрэл сацран мөнхийн хутагт нэгэн сүнс ээлжит үйлийн зараалаар эхийн хэвлийд морилмой.
- 12

Lotus fronds in the Sun / Наран лянхуа, 2024
Mixed media, 50 x 60cm

Нарт орчлонд ирээд буцахаас бусдаар бид бүхний харж заншсан юмс үзэгдэлд туйлын үнэн оршдоггүй. Хоосон чанарын эргүүлэг дунд үнэмлэхүй үнэнийг, оршихуйн утга учрыг эрэлхийлэн бэдрэх хүмүүн адил, ариун нандины бэлгэдэл лянхуаны цоморлог бидний мэлмий үл хүрэх ногооноор дэлгэрч, наран адил навч юу нь ягааран гэрэлтдэг байж болох биз ээ.
- 13

Orchikui – 1 / Орчихуй – 1, 2024
Mixed media, 60 x 80cm

Ирсэн бол буцах учиртай, олон хэмжээст орчлонгийн эцэс төгсгөлгүй эргэлт, хаа хүрч хэрхэн дуусахыг хэн ч үл мэднэ.
- 14

Soul of the Petroglyphs / Сүг зурагний орчил, 2021
Mixed media, 100 x 100cm

Судалгаа хийн сүг зураг үзэж суухдаа сүг зураг дээрх ан амьтан, мал ахуйн дүрслэлийг амьдруулан төсөөлтөл улайран шаргалтах наран зүгт тал нутагт сүг зурган сүрэг зэрэглээтэн сүүмэлзэнхэн налайж, тэднээс талын сайхан шар цэцэгс урган байх шиг үзэгдэж билээ. Сүг зургаас урлаг ургасан гээд бодвол талын шар цэцэгс сүг зургаас ургаж бас болох биз ээ.
- 15

Spirit of Populus euphratica / Улиангарын амин сүнс, 2021
Mixed media, 60 x 80cm

Уг бүтээлийг БНХАУ-ын Шинжаан Уйгурын өөртөө засах оронд зохион байгуулагдсан судалбар зургийн аяны хүрээнд улиангарын ойд зурсан. Их бие нь хатаж холцруутан үхширмэл үзэгдэх атал гордойж гүрдийсэн улиангарын мөчрийн үзүүрт улаан шаргал, ногоон шар өнгийн навчис чуулан байх нь соньхон. Улиангар цөлөрхөг хөрсний гүн дэх усны нөөцийг тогтоон барьж, шим шүлт хамаг шингэнээ өөрийн их биед бус нялх мөчир, навчисаа зориулдаг нь эх хүн алив бүхнээ үрдээ зориулдагтай агаар нэг. Үхэл амьдралын заагт хат заан орших хүчирхэг чанараараа асан дүрэлзэх гал адил улиангар нь нүүдэлч түмний мөнхийн шүтээн наран саран мэт хүндтэй.
- 16

All things / Түмэн бодис, 2021
Acrylic on canvas, 100 x 100cm (diameters)

Хоёр өөр цаг үе, орчинд ээж минь надтай өрнүүлсэн яриан дундаа «Хэрэв би зурж чаддаг сан бол алагхан цэцгийг тойрон эргэлдэх зөгийн сүргийг зурах сан. Яг л сайхан бүсгүйг эрэн хөөцөлдөх залуу сарчуул шиг!» гэж билээ. Ийнхүү хэлэх бүрийн хэв миний санаанд ямагт ганц томоо шаргал наран цэцгийг тойрон эргэлдэх зөгийн сүрэг төсөөлөгдсөн. Уг төсөөлөл ер сэтгэлээс гарч өгөхгүй ээрэгдсээр эхийнхээ энэ санааг би л амьдруулах учиртай юм байна гэж ухаарч, монгол зураг, хээ угалзын бүтээл буулгасан маань энэ.

Хүтээлийн дийлэнх орон зайг эзлэн шаргалтах том наран цэцгийг төсөөлөлд анх хэрхэн буусан яг тэр байдлаар нь буулгасан бөгөөд байгалийн зүг чиг, ээлжлэх дөрвөн улирлын эргэлтийг хээ угалз хэлбэрт хувиргасан дөрвөн зүг найман зовхист нисэлдэх зөгийнүүдэд давхар хураангуйласан. Наран цэцгийн төвд нэгэн орон зайд арга билгээ тээн эргэлдэх алхан хээт даль бүхий хас хээ нь ирж буцах хорвоогийн жам, дэлхий ертөнцийн мөнхийн эргэлт, сансар огторгуйн нууцлаг оршихуй, хүмүүн байгалийн нягт уялдаа холбоог илэрхийлж буй.
- 17

Mongol / Монгол, 2007
Oil on canvas, 130 x 110cm

«Монгол» хэмээх бүтээл нь Этүгэн эхийг бэлгэдсэн шороон шаргал дэвсгэрт гурав дагнааст хээний уламжлалт цоглог тод өнгөнүүдээс бүрдсэн бөгөөд нүүдэлч түмний өнө эртнээс малч, анч аж амьдралаасаа ажиглан мэдсэнээ хээ угалз хэлбэрт буулган үрээс уламжлан ахуй амьдралдаа өргөн хэрэглэж ирсэн байгалийн, бэлэгдлийн, геометрийн, ургамлын, амьтны гэх үндсэн 5 төрөл зүйл ангиллын хээ угалзуудын цогц юм.

Бүтээлийн орон зайн төвд амьтны гаралтай хээ угалзын төлөөлөл болгон Хүннү гүрний үед хамаарах Ноён уеолын археологийн үнэт олдвор эсгий ширмэл хивсний дөрвөлж хүрээнд буй өөр овог төрлийн амьтдын амь өрссөн арсалдааныг хээ дүрсээр уран яруу өгүүлсэн хээнүүдээс онцлон сонгосон. Туурайтан болон араатан, тэнгэр хийгээд газрын амьтдын тэмцлээр хүчтэй нь хүчгүйг эрхшээд байгалийн хууль, хоол тэжээлийн гинжин хэлхээг бүрнээ илэрхийлдэг. Эдгээр амьтны дунд мөнхүү хивснээ дүрслэгдсэн амьдралын мод, чанх дээр нь бэлэгдлийн хээний төлөөлөл болгон лянхуа суурьт Соёмбо, хоёр талаар нь нөмөрлөн хамгаалах хамар болон эвэр угалзын хоршил, орой дээр нь гуравлах холбоог үүсгэх арван гурван нүдэт өлзий болон навч цэцгээр угалзан сунайх хоршил хээ нь эдийн дээд хадгийн илэрхийлэл. Бүтээлийг зохиомжлохдоо уламжлалт хээ угалзын тэгш хэмийн давтамжит дэг жаягаар хоршоо хээнүүд үүсгэн хослуулсан бөгөөд Соёмбын харалдаа доорх орон зайд эр эм хас дөрвөн цагийг эргэлтэд нэгэн үүрднээ дөрвөн зүг найман зовхист нүүдэллэн аж төрөх нүүдэлч ахуйг илтгэн буй. Наран саран голчтой хамар ба эвэр угалзын хоршлоос бүрдсэн өрх гэрийн илэрхийлэл цэцгэн хээний дөрвөл, байгалийн хээний төлөөлөл болох үүл, уул, усан хээ, өсөн дэвжиж мандан бадрахын бэлгэдэл байгалийн хүчин зүйлийн төлөөлөл гал хээ, өнгийн цэцэгс ургамал ногооны хамт орон зайг эмжээр даран хөвөөлсөн зохиомж бүхий бүтээл юм.
- 18

Essence of the Natural World / Байх Гал, 2019
Oil on canvas, 40 x 50cm

Үндэсний хээ угалз түүх, нийгмийн олон үе нугачаанд уламжлагдахдаа зэргэлдээх овог аймаг, улс орны соёлын солилцоонд арвижин баяжиж, тодорхой түвшинд харилцан шинэчлэгдэхдээ үндэстэн угсаатан бүрийн ондооших хэв шинжийг хадгалан хөгжсөн. Уг нандин чанарыг орхигдуулахгүй залгамжлах эрхэм үүрэг хариуцлагын хүрээнд хүмүүний гэгдэлийг ямагт сэрэн эзэмдэх гайхам үндист байгаль дэлхий минь үрийн үрд тэнцвэрээ хадгалан орших өлзийт ерөөл өргөн, уламжлалт хээ угалзын байгалийн, бэлэгдлийн, геометрийн, ургамлын, амьтны гэх 5 зүйл ангиллаас монголчуудын ахуй амьдралд түгээмэл тохиолддог байгалийн гаралтай хээ угалзуудад төвлөрөн, гэгээлэг тод өнгийн дэг жаягийнх нь хамт дүүргэн бүтээсэн юм.
- 19

Shaman / Бөө, 2022
Mixed media, 50 x 70cm

Хүн төрөлхтний уугуул шүтлэг яахын аргагүй бөө мөргөл бөгөөд энгийн нэгний мэлмийн хязгаараас давуу, мэдрэхүйн түвшингээс дээгүүрх олон хэмжээст орших бөөн эрчисийг бөөгнүүлэн харилцах чадвартныг бөө хэмээнэм.

Prices available upon request

+976 7570 8080 / info@lkhamgallery.com